

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шивээговь сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2025/003/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Говьсүмбэр аймаг
2025 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: nananbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

Г ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ШИВЭЭГОВЬ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Ч.СУГАРМАА ТАНАА

2025.03.24

№ 54

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

422502228

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,125,656.80	1,161,420.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	728,698.20	729,614.40
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	218,850.10	150,125.60
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	44,634.00	85,839.00
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	27,099.50	63,250.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	106,375.10	132,591.90
2	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН БУС		1,235,860.40	1,163,101.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,235,860.40	1,163,101.50
39200	Биет хөрөнгө		1,220,851.60	1,025,542.70
39300	Биет бус хөрөнгө	13	15,008.80	137,558.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,361,517.20	2,324,522.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		36,976.90	100,201.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	36,976.90	100,201.80
41300	Өглөг	17а, 17б	36,976.90	100,201.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,324,540.40	2,224,320.50
51	Засгийн газрын хувь оролцоо		2,324,540.40	2,224,320.50
51100	Засгийн газрын оруулсан капитал		643,941.30	643,941.30
51200	Хуримтлагдсан үр дүн		913,140.30	812,920.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		767,458.80	767,458.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,361,517.20	2,324,522.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		5,294,873.20	4,613,663.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,933,301.00	2,471,630.50
110	Орлогын албан татвар		1,621,793.50	2,179,424.00
1100	Хувь хүний орлогын албан татвар		1,670,410.80	2,245,845.20
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-48,617.20	-66,421.20
113	Хөрөнгийн албан татвар		239,021.10	227,344.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж		72,486.40	64,861.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	607,973.90	478,785.50

120	Нийтлэг татварын бус орлого		607,973.90	478,785.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,753,598.20	1,663,247.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	4,449,974.70	4,709,554.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,449,974.70	4,709,554.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,284,066.60	4,194,623.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		523,294.20	715,429.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		64,260.70	84,416.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		103,117.20	514,413.40
2104	Хангамж, бараа материалын зардал		593,535.70	2,002,159.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		20,697.60	43,581.60
2107	Томилолт, зочны зардал		11,904.00	15,352.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		460,089.40	84,142.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		507,167.70	735,127.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,165,908.20	514,930.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		844,898.50	-95,891.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		460	1,833.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		844,438.50	-97,724.00

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		4,760,930.30	4,355,150.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,933,301.00	2,471,630.50
110	Орлогын албан татвар		1,621,793.50	2,179,424.00
1100	Хувь хүний орлогын албан татвар		1,670,410.80	2,245,845.20
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-48,617.20	-66,421.20
113	Хөрөнгийн албан татвар		239,021.10	227,344.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж		72,486.40	64,861.80

1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		47,587.50	22,985.50
1181	Газрын төлбөр		24,899.00	41,876.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		74,031.00	220,272.40
120	Нийтлэг татварын бус орлого		74,031.00	220,272.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,753,598.20	1,663,247.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,576,472.60	2,297,485.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,576,472.60	2,297,485.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,345,130.70	1,692,146.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		520,819.00	730,964.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		65,319.20	84,472.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		103,117.20	514,413.40
2104	Хангамж, бараа материалын зардал		26,360.90	41,036.50
2105	Нормативт зардал		299.5	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		34,790.60	82,058.50
2107	Томилот, зочны зардал		12,046.00	15,352.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		521,042.40	118,564.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		61,335.80	105,283.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,231,341.90	605,339.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		1,184,457.70	2,057,664.30
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		644,905.60	1,962,383.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		644,905.60	1,962,383.50
2200	Дотоод эх үүсвэрээр		644,905.60	1,962,383.50
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-644,905.60	-1,962,383.50
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-115,680.80	-876.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		115,680.80	876.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		423,871.30	94,404.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		304,826.90	728,698.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		728,698.20	729,614.40

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,562,427.30	0	1,562,427.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-82,325.40	0	-82,325.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,480,101.90	0	1,480,101.90
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	844,438.50	0	844,438.50
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,324,540.40	0	2,324,540.40
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,324,540.40	0	2,324,540.40
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,495.90	0	-2,495.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,322,044.50	0	2,322,044.50
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	-97,724.00	0	-97,724.00
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,224,320.50	0	2,224,320.50

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,459,910.0	3,820,507.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,289,730.5	1,844,740.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,980,450.5	1,731,816.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	882,499.7	730,964.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,308.8	84,472.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	523,792.0	514,413.4
2104	Хангамж, бараа материалын зардал	42,660.0	40,326.5

2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	128,383.0	127,127.9
2107	Томилолт, зочны зардал	15,424.0	14,472.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	130,993.0	118,399.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,390.0	101,639.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	309,280.0	112,923.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	299,380.0	105,028.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,900.0	7,895.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,062,230.3	1,974,890.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	107,949.2	876.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,459,910.0	3,510,559.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,701,000.0	1,638,270.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,079,868.8	1,795,999.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	679,041.2	76,289.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	594,561.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	284,614.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,976.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,976.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,755.0
2104	Хангамж, бараа материалын зардал	710.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	165.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,221.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,221.3
213208	Хөдөө орон нутагт тогтворт суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,221.3
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,976.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,976.3

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар Шивээговь сумын ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдаж буй байгууллагуудад Шилэн данс, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илэрсэн, өмнөх оноос зөрчлийн дүн нэмэгдсэн, хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1, 15 дугаар зүйлийн 15.4.1, 15 дугаар зүйлийн 15.4.2, Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1 дүгээр зүйлийн 1.1.3, 1.1.10 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын санхүүгийн тайланд нэгтгэгдэж буй харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд тус бүр хяналтыг хэрэгжүүлж, алдаа, зөрчлийг бууруулах төлөвлөгөө гарган ажиллах

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шивээговь сумын Засаг дарга нь төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийг хангаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “*төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх*”, 54 дүгээр зүйлийн 54.5-д “*Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна*”, дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлж байх

5. Аудитын илрүүлэлт:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 248.2 сая төгрөгийн 1 алдаа илэрсэн бөгөөд аудитын явцад залруулга хийсэн байна.

Аудитаар нийт 6.9 сая төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс, 6.9 сая төгрөгийн 4 зөрчилд 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн, нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад “Өөрчлөлтгүй” дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,197.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 414.3 сая төгрөгийн 11 алдааг аудитын явцад залруулж, 1.0 сая төгрөгийн 1 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 741.8 сая төгрөгийн 4

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зөрчилд 4 албан шаардлага, 40.1 сая төгрөгийн 4 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн 91%-аар өссөн ба үүнээс: залруулга 77.3%, албан шаардлага 99.3%, зөвлөмж 90.5%-аар тус тус өссөн, төлбөрийн акт 66.7%-аар буурсан үзүүлэлттэй байна. Нийт зөрчлийн дүн, албан шаардлага, зөвлөмж нь Шилэн дансны тухай хууль болон бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Залруулагдаагүй нийт зөрчлийн 33.4 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлаас бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

5.1 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төлбөрийн акт, албан шаардлага байхгүй.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Орон нутгийн орлогод 11, 12 сард төвлөрсөн Малын тоо толгойн албан татварын 5,546.4 мянган төгрөгийн орлогын санхүүжилтийн эрхийг нээгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.5-д “бүх орлого”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, , 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1-д “Төрийн сан төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг Төсвийн тухай хуулийн 37.1.8-д заасны дагуу төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн олгоно” дэх заалтуудыг тус тус зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сар бүр татварын орлогын санхүүжилтийн зарцуулалтын эрхийг нээх, хяналтыг хэрэгжүүлэх

2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Сумын нэмэлт санхүүжилтийн дансанд 2023 онд төвлөрүүлсэн 1,344.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг 2 жил дамжин зарцуулаагүй үлдэгдэлтэй тайлагнаж, ОНХО-д төвлөрүүлээгүй дараа оны санхүүгийн эх үүсвэрээр батлуулж, эргэлтэд оруулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” дахь заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: 2 жил дамжин сумын нэмэлт санхүүжилтийн дансанд үлдэгдэлтэй байгаа мөнгөн хөрөнгийг эх үүсвэрээр батлуулж, эргэлтэд оруулах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шивээговь сумын Засаг дарга	1	248.2	-	-	1	248.2	1	248.2				
Шивээговь сумын ИТХ	3	19.0	1	0.0	2	19.0	3	19.0				
Шивээговь сумын ЗДТГ	7	297.9	3	3.5	4	294.4	7	297.9				
Шивээговь сумын ОНХС	1	97.4	-	-	1	97.4	1	97.4				
Шивээговь сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-				
Дүн	12	662.5	4	3.5	8	659.0	12	662.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шивээговь сумын Засаг дарга	2	6.9	-	-	-	-	2	6.9				
Шивээговь сумын ИТХ	1	3.4	-	-	-	-	1	3.4				
Шивээговь сумын ЗДТГ	2	1.0	1	1.0	-	-	1	0.0				
Шивээговь сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-				

Шивээговь сумын ХХС	1	8.2	-	-	1	8.2	-	-				
Нийт	6	19.5	1	1.0	1	8.2	4	10.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шивээговь сумын Засаг дарга	1	0.0					1	0.0
Шивээговь сумын ИТХ	-	-						
Шивээговь сумын ЗДТГ	1	0.0					1	0.0
Шивээговь сумын ОНХС	1	719.8			1	719.8		
Шивээговь сумын ХХС	1	36.7					1	36.7
Дүн	4	756.5			1	719.8	3	36.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шивээговь сумын Засаг дарга	1	0.0					1	0.0
Шивээговь сумын ИТХ	1	5.2			1	5.2		
Шивээговь сумын ЗДТГ	1	8.7			1	8.7		
Шивээговь сумын ОНХС	-	-						
Шивээговь сумын ХХС	-	-						
Дүн	3	13.9			2	13.9	1	0.0
Нийт дүн	7	770.4			3	733.7	4	36.7

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	4	1	3		1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	5	2	3		2			

